

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2021 оны 01 дүгээр сарын мэдээлэл

2021.01.22.

Нэг. Төрийн удирдлагын чиглэлээр:

1/. Сумын ИТХТ-ийн хурлаар “Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зарцуулалт, бүрдүүлэлтэд хяналт тавих орон тооны бус” зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Мөн ИТХ-ээлжит 4 дүгээр хуралдаанаар “Малын тоо толгойн татварын хувь хэмжээг” тогтоож, үхэр, хониноос 600 төг, адуу, ямаанаас 900 төгрөг, тэмээнээс татвар авахгүй, 200 хүртэл толгой малтай малчин өрх, 100 хүртэл толгой малтай мал бүхий өрхийг тус тус татвараас чөлөөлөхөөр тогтлоо.

2/. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөөгөө батлууллаа.

3/. Сумын Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг боловсруулан хянуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Тамгын газрын даргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллаж , 82 зорилт, 202 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хянуулан, зөвлөгөө авч, хөтөлбөрийг тодотгон ИТХ-аар баталгаажууллаа.

4/. 2021.01.12 нд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэн, зохих арга хэмжээг авлаа. Үүнд: а/. Сумын нэгдсэн дулаан халаалтын асуудал

б/. Газар өмчлөл, эзэмшилд дэд бүтцийн асуудал

в/. Цэцэрлэгийн шинэ байр барихтай холбогдуулан газар чөлөөлөлтийн асуудал

5/.Сумын Засаг даргын шийдвэрээр “Болзошгүй гамшиг эрсдэл, нийгмийн эрүүл мэндийн ноцтой нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож, ажиллах баг бүрэлдэхүүнийг томилгоожуулсан.

6/. Ёс зүйн зөвлөлийг Тамгын газрын даргаар ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсон.

7/. Коронавирусийн халдварын тархалтын улмаас хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн нөхцөлд сумын ЖДҮ, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх , ажлын байрыг хапгалах зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-гийн 2018, 2019, 2020 оны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан , эргэн төлөлт хэвийн иргэн, аж ахуйн нэгжийн 2021.01.01-2021.07.01 нийг хүртэлх хугацааны зээлийн үндсэн төлбөр, хүүг нь түр хугацаагаар хойшлуулж, зээл төлөх үндсэн хуваарьт нь өөрчлөлт орууллаа.

8/. 2020 онд Орон нутгийн хөгжлийн сан болон шилжих хөрөнгө оруулалтаар хийгдсэн уурын зуухны шинэчлэлийн ажлыг хүлээн авах ажлын

хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж зуухыг хүлээн авлаа.

9/. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, аймгийн ОБГ-т хүргүүлээ.

Хоёр. Сургалт сурталчилгааны чиглэлээр.

1/. 2021.01.13 нд “Тохиолдлын удирдлагын тогтолцоо салбар хоорондын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг аймгийн ОБГ, МХГ, ЭМГ-ын хамтарсан баг суманд ирж зохион байгуулж, 25 албан хаагчдад дадлага хийлгүүлж, үүрэг даалгавар өгч ажиллалаа.

2/. Төрийн албан хаагчдад Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудыг танилцуулж, байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаар мэдээллийг цахимаар болон танхимаар өгсөн.

3/. ХАСХОМ гаргах 11 төрийн албан хаагчдын мэдээллийг аймгийн ХЭЗХ-ийн мэргэжилтэнд хүргүүлж, дээрх албан хаагчид мэдүүлгээ цахимд гаргаж байна.

Гурав. Сургууль, цэцэрлэгийн талаар

1 дүгээр сард хийх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаж байна.Үүнд 20 чиглэлийн үйл ажиллааны төлөвлөгөө гаргаж Хүүхэд хамгаалал аюулгүй ажиллагаа чиглэлээр туслах багш нар штрoк бэлтгэж цахим орчинд байршуулан ажиллаж байна.

Бүлгийн багш нар powtoon праграмм болон powerpont ашиглан цахим хичээл заах чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр:

Ковид-19 болон Томуугийн дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж, цаг үеийн мэдээг холбогдох газруудад тухай бүрт мэдээллэн ажиллаж байна. Мөн томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, гараа хэзээ хаана хэрхэн зөв угаах, халтиргаа гулгаанаас сэргийлэх, осголт хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх сургалтыг үйлчлүүлэгчдэд болон хэвтэн эмчлүүлэгчдэд тогтмол хийж байна. Хэвтэн эмчлүүлэгч 23, амбулаторийн 207 үйлчлүүлэгчдэд, нийт 230 ширхэг гарын авлага, зөвлөмж тарааж мэдээлэл олгосон.

Олон нийтийн сүлжээгээр 120 удаагийн мэдээлэл, зөвлөмж зөвлөгөө оруулж хандалт 2335 байна.

Улсын хэмжээнд 3-5 насны хүүхдүүдэд “Халдварт саа”-гийн нөхөн дархлаажуулалт хийгдэж байгаатай холбогдуулан 2021 оны 01 сарын 21 нд вакцинаа татан авч 01 сарын 22-ны өдрөөс эхлэн хийгдэж байна. Үүнд: 170 хүүхэд хамрагдахаас 32 хүүхдийг вакцинжуулаад байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

-Сумын Засаг дарга болон орлогч даргаар ахлуулсан баг сумын I , II багийн малчин өрхүүдээр биечлэн очиж өвөлжилтийн байдалтай танилцан, цаг үеийн мэдээлэл өгч ажиллалаа. Нийт 84 хот айлаар орж мэдээлэл солилцоход малчид өвөлжилт хүндэрч болзошгүй, бэлчээр хүрэлцэхүй тул ядарч муудсан

малыг тэжээлд оруулахад өвс тэжээл хэрэгтэй байгаагаа ажлын хэсэгт танилцуулсны дагуу зохих арга хэмжээг авлаа. Мөн энэ үеэр “Манлайлагч малчин өрх” шалгаруулах уралдааны болзлыг танилцуулсан.

-Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, ширийг хоршоогоор дамжуулан тушаасан 265 малчдын баримт буюу хонины 266, ямааны 135, үхрийн 284 ширхэг паданыг программд шивж, аймгийн ХХААГ-т хүргүүлээ.

- 2020 оны хүн ам, мал тооллогын дүн мэдээг хугацаанд нь тушаасан. Үүнд: а/. Хүн ам 3126, өрх 929, малчин өрх 507, малтай өрх 287, мал бүхий өрх 797, нийт мал 224403 толгой тоологдсоноос тэмээ-159, адуу 24781, үхэр 22410, хонь 112388, ямаа 65180 байна.

-Аймгийн ХХААГ-т малын зүй бусын хорогдол болон мал аж ахуйн өвөлжилтийн мэдээг 7 хоног бүр мэдээлж байгаа.

-Зудын эрсдлийн судалгааг гаргахад цагаанаар зудархуу гэж үнэлэгдсэн.

Байгаль хамгаалах чиглэлээр:

-Иргэдийн гомдлын мөрөөр 6 айлд ил задгай хог, хаягдал угаадсаа асгаад байгаа зөрчилд нь Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцлоо.

-Сумын БЦГХЗ-ны дарга сумын ИТХ-ын ажлын албанд болон сумын Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн нарыг байлцуулан байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажил, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо.

МЭДЭЭЛЛИЙГ НЭГТГЭСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР